



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд
амьдрах эрхийг хангах талаар авах
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Агаарын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд, нийслэлийн Засаг даргын хамтарсан А/04-А/16 дугаар тушаал, захирамж, тус газрын дүрмийн 2.5.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа /зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, амралтын газар, гэр буудал/ эрхлэх зөвшөөрөл олгохдоо Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журамд заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байгаа байдлыг тодорхой үзүүлэлт болгон харгалзан үзэхийг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д даалгасугай.

2. Улаанбаатар хотын иргэдийг эрүүл агаарт амралт чөлөөт цагаа өнгөрөөх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны бааз, амралтын газар, гэр буудлуудыг өвлийн улиралд хямдралтай үнээр үйлчилгээ үзүүлэх уриалга гаргаж хэрэгжүүлэхийг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

D. Batsoy

Д.БАТСҮХ



1150500033